

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бат Өлзий сумын Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨВА-2022/7/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn

Арвайхээр хот

2022 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukhd@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг

Утас: 70323108 Цахим хаяг:

Аудитор: Д.Дашзэвэг

Утас: 95329926 Цахим хаяг: dashzeveg_d@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллагын үйл ажилагаа	8
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	8
4. Аудитын тайлан	8
4.1 Ерөнхий зүйл	10
4.2 Дотоод хяналт	10
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
4.4 Материаллаг байдал.....	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	11
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
8. Аудитын илрүүлэлт.....	12
8.1 Залруулсан алдаа	12
8.2 Төлбөрийн акт	12
8.3 Албан шаардлага	12
8.4 Зөвлөмж.....	12
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2022.09.18 № 829
танай _____-ны № _____-т

БАТ ӨЛЗИЙ СУМЫН ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Г. БЯМБАГАРАВ ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Бат Өлзий сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бат Өлзий сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

015030656

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/төгрөгөөр/	
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
1	ХӨРӨНГӨ	0.0	0.0	
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.0	0.0	
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7,012,300.0	2,013,488.68	
1.1.2	Дансны авлага	0.0	0.0	
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	0.0	0.0	
1.1.4	Бусад авлага	0.0	0.0	
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.0	0.0	
1.1.6	Бараа материал	1,120,000.0	1,120,000.0	
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.0	0.0	
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.0	0.0	
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.0	0.0	
1.1.10		0.0	0.0	
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	8,132,300.0	3,133,488.68	
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	37,400,000.0	39,920,000.0	
1.2.1	Үндсэн хөрөнгө	37,400,000.0	39,920,000.04	
1.2.2	Биет бус хөрөнгө	0.0	0.0	
1.2.3	Биологийн хөрөнгө	0.0	0.0	
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.0	0.0	
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.0	0.0	
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.0	0.0	
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.0	0.0	
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.0	0.0	
1.2.9		0.0	0.0	
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	0.0		
1.3	Нийт хөрөнгийн дүн	45,532,300.0	43,053,488.72	
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.0	0.0	
2.1	ӨР ТӨЛБӨР	0.0	0.0	
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		0.0	
2.1.1.1	Дансны өглөг	7,000,000.0	0	
2.1.1.2	Цалингийн өглөг	0.0	0.0	
2.1.1.3	Татварын өр	326,560.0	0	
2.1.1.4	НДШ - ийн өглөг	0.0	0.0	
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.0	0.0	
2.1.1.6	Хүүний өглөг	0.0	0.0	
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.0	0.0	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	0.0	0.0	
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	0.0	0.0	
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		0.0	
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	0.0	0.0	

2.1.1.12		0.0	0.0
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	7,326,560.0	0
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.0	0.0
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	0.0	0.0
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.0	0.0
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.0	0.0
2.1.2.5		0.0	0.0
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.0	0.0
2.2	Өр төлбөрийн нийт дүн	7,326,560.0	
	ЭЗДИЙН ӨМЧ	0.0	0.0
2.3	Өмч	32,900,000.0	32,900,000.0
2.3.1	-төрийн	32,900,000.0	32,900,000.0
2.3.2	-хувийн	0.0	0.0
2.3.3	-хувьцаат	0.0	0.0
2.3.4	Халаасны хувьцаа	0.0	0.0
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.0	0.0
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.0	0.0
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.0	0.0
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	0.0	0.0
2.3.9	Хуримтлагдсан ашиг	5,305,740.0	10,153,488.72
2.3.10		0.0	0.0
2.3.11	Эздийн өмчийн дүн	38,205,740.0	43,053,488.72
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	45,532,300.0	43,053,488.72

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	39,240,000.00	36,747,840.00
2	Борлуулалтын өртөг	0.00	0.00
3	Нийт ашиг (алдагдал)	39,240,000.00	36,747,840.00
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	0.00	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	0.00	10,000,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	33,934,260.00	41,900,091.28
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	0.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00

16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	5,305,740.00	4,847,748.72
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	5,305,740.00	4,847,748.72
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	5,305,740.00	4,847,748.72
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	32900000				5305740	38205740
Тайлант үеийн үр дүн					4847748,72	4847748,72
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	32900000				10153488,72	43053488,72

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн	32,240,000.00	36,747,840.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	32,240,000.00	36,747,840.00

1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.00	0.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	27,727,700.00	41,746,651.32
1.2.1	Ажиллагчдад төлсөн	8,073,440.00	18,561,885.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,036,560.00	4,970,106.32
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,277,810.00	15,000.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0.00	0.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	13,477,250.00	6,500,520.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	0.00	0.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	3,862,640.00	11,496,540.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,512,300.00	-4,998,811.32
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн	0.00	0.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.00	0.00
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.1.8		0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн	4,500,000.00	
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,500,000.00	
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.2.6		0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-4,500,000.00	
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн	7,000,000.00	
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	7,000,000.00	
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4		0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	0.00	0.00

3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,000,000.00	
4	Валютын ханшийн зөрүү	0.00	0.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	7,012,300.00	-4,998,811.32
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	0.00	7,012,300.00
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	7,012,300.00	2,013,488.68

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2021 оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	20,160.00	18,561.90	1,598.1	92.07
2	Байгууллагаас төлөх ЭМНДШ	2,721.60	4,970.10	-2,248.5	182.62
3	Бусад татвар хураамж	0.00	0.00	0.0	
4	Цахилгааны төлбөр			0.0	
5	Нүүрс модны зардал			0.0	
6	Түлш, шатахуун тээврийн зардал	1,500.00	1,475.50	24.5	98.37
7	Албан томилолтын зардал		82.60	-82.6	
8	Засвар, үйлчилгээний зардал			0.0	
9	Сэлбэг хэрэгслийн зардал	5,000.00	5,025.00	-25.0	100.50
10	Түүхий эд материалын зардал			0.0	
11	Хөдөлмөр хамгааллын зардал	150.00	120.00	30.0	80.00
12	Холбоо, бичиг хэргийн зардал			0.0	
13	Газар байгалийн нөөц ашигласан төлбөр			0.0	
14	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	11,000.0	10,849.7	150.3	98.63
15	ТҮЗ-ын зардал			0.0	
16	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал			0.0	
17	Аудитын хөлс	650.0	646.8	3.2	99.51
18	Сургалтын зардал			0.0	
19	Ажиллагсдын нийгмийн зардал			0.0	
20	Удирдлагын зардал			0.0	
21	Бусад зардал	100.00	15.00	85.0	15.00
	БАЙГУУЛЛАГЫН НИЙТ ЗАРДАЛ	41,281.6	41,746.6	-465.0	101.13

	ОРЛОГО	41281.6	36747.8	4,533.8	89.02
	ОРЛОГЫН ДҮН	41281,6	36747,8	4533,8	89,02
	АШИГ+, АЛДАГДАЛ-	5305,7	4847,7	458,0	91,4

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Бат Өлзий сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГГазар нь “Бат-Өлзий сумын иргэдийг хоггүй, эрүүл, аюулгүй, цэвэр эко орчинд амьдрах ая тухыг бүрдүүлэн дэвшилтэт технологиор нийтийн үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэхэд оршино” гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

Байгууллагын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Сумын ард иргэд аюулгүй байх үүднээс нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламж, авто зам, парк, хүүхдийн тоглоом, гүүр, цэцэрлэгт хүрээлэн гэх мэт газар арчлалт хамгаалалт, засвар үйлчилгээ, усалгаа гэх мэт бүх төрлийн үйлчилгээ тоног төхөөрөмж, машин механизмыг үр ашигтай ажиллуулах түүнд нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх” гэж тодорхойлжээ.

Тус байгууллага нь 2021 онд Бат Өлзий сумын ЗДТГазраас 36747,8 мянган төгрөгийн санхүүжилт авч сумын төвийн гэрэлтүүлэг засварт 4700,0 мянган төгрөг, сумын төвийн зам арчилгаа засварт 5434,5 мянган төгрөг, золбин нохой устгахад 3192,0 мянган төгрөг зарцуулсан байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд 100 хувийн орон нутгийн өмчийн статустай байна. Төлөөлөгч хэрэгжүүлэгч нь Засгийн газраас эрх олгосон төрийн захиргааны байгууллага болох Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Бат Өлзий сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн №10/14 тогтоолоор Бат Өлзий тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулагдсан. Одоо удирдах ажилтан-1, гүйцэтгэх 3, нийт 4 ажиллагсадтайгаар ажиллаж байна.

Ажиллагсдын цалин, урамшууллыг 420,0 мянган төгрөгөөр тогтоосон нь цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Бат Өлзий сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГГазрын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7012,3	2013,5	-4998,8
БХХО			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	1120,0	1120,0	0,0
Үндсэн хөрөнгө	37400,0	39920,0	2520,0
Биет бус хөрөнгө			
Нийт хөрөнгийн дүн			
Өр төлбөрийн дүн	7326,6		
Богино хугацаат өглөг			
Урт хугацаат өглөг			
Эздийн өмч	38205,7	43053,5	-4847,8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	45532,9	43053,5	-2479,4

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлгүй

Тус байгууллагын Төрийн банк дахь харилцах дансанд оны эхэнд 7,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол 37,9 сая төгрөг орж 42,9 сая төгрөгийн зарлага гарч оны эцэст 2,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансанд ажлын хувцасны 1,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол тайлант онд 6,6 сая төгрөгийн бараа материал худалдан авч зарцуулан оны эцэст 1,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч өмнөх оноос өсөөгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй .

Үндсэн хөрөнгө дансны хувьд оны эхэнд 37,4 сая төгрөгийн хөрөнгө байсан бол тайлант онд сумын ИТХ-ын шийдвэрээр сумын ЗДТГазраас 10,0 сая төгрөгийн гэрлийн шугамыг үнэ төлбөргүй шилжүүлэн авч оны эцэст 47,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Оны эхэнд богино хугацаат өр төлбөр дансанд зээл 7,0 сая төгрөг, хувь хүмүүст төлөх 0,3 сая төгрөгийн өглөгтэй байсан бол тайлант онд эдгээр өглегийг бүрэн барагдуулж өр төлбөрийн үлдэгдэлгүй болсон байна

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Бат Өлзий сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тус байгууллагын хувьд 2021 онд үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж батлуулсан зүйл байхгүй байна. Зөвхөн Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаас Сумын ЗДТГазар дээр Тохижилт үйлчилгээний ажилчдын цалинд 22881,6 мянган төгрөг, гэрэлтүүлэг засварт 5000,0 мянган төгрөг, зам засвар арчилгаанд 5000,0 мянган төгрөг, хог тээврийн зардалд 1348,2 мянган төгрөг, бүгд 34229,8 мянган төгрөгийн зардал батлагдсан байна.

Гүйцэтгэлээр 34229,8 мянган төгрөгийн санхүүжилт авч өөрийн үйл ажиллагааны орлогоос 2518,0 төгрөг, өмнөх оны харилцах дансны үлдэгдэл 7012,3 мянган төгрөг бүгд 43760,1 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж 41746,7 мянган төгрөгийн зардал гаргаж 4847,7 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бат Өлзий сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг, анхан шатны баримтын хөтлөлт зэрэгтэй холбоотой асуудалд өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дөлгөөнхайрхан Уул Аудит ХХК-ийн аудитор Д.Дашзэвэг гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Гансүх, аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор О. Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

. Бат Өлзий сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ газар нь 2021 оны санхүүгийн тайланг Дөлгөөнхайрхан Уул Аудит ХХК-д 2021 оны 02 дугаар сарын 26-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Тус байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллага нь байгуулагдаад удаагүй одоогоор Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөөгүй байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Бат Өлзий сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 33,9 сая төгрөгөөс 1,5 хувиар буюу 0,7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд тус байгууллага нь шинээр байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлснээс хойш шилэн дансны цахим системд бүртгүүлж, нэвтрэх эрх аваагүй мэдээлэл огт оруулаагүй байна. Бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ба материаллаг хэмжээний алдаа зөрчил илрээгүй тул зөрчилгүй дүгнэлт өгсөн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	0	0	0	0	0	0	
Албан шаардлага	0	0	0	0	0	0	
Зөвлөмж	0	0	0	0	0	0	
Нийт дүн	0	0	0	0	0	0	

7. Дараагийн аудитаар анхан шатны бүртгэл хөтлөлтөд анхаарах

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар хэрэгжүүлсэн горим сорилоор материаллаг хэмжээний алдаа зөрчил илрээгүй ба цаашид анхаарч хэрэгжүүлэх шаардлагатай 3 зөвлөмж өгсөн болно.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой залруулах шаардлагатай асуудал гараагүй болно.

8.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоохоор алдаа зөрчилтэй асуудал гараагүй.

8.3 Албан шаардлага

Аудитаар хэрэгжүүлсэн горим сорилоор албан шаардлага өгөх асуудал гараагүй.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага нь шинээр байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлснээс хойш шилэн дансны цахим системд бүртгүүлж, нэвтрэх эрх аваагүй мэдээлэл огт оруулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3-р зүйлийн 3,1-д Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим системд шинээр бүртгүүлэн, нэвтрэх эрх авч хуулийн дагуу мэдээллээ оруулж байх

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шинээр боловсруулж мөрдөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18,2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагынхаа үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг шинээр боловсруулж мөрдөх

3. Анхан шатны бүртгэл хөтлөлтийн талаар

Илрүүлэлт:

Аудитаар бараа материалын тайланг зохих заавар журмын дагуу хөтлөөгүй шаардах хуудас бичээгүй зэрэг асуудал илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалын тайланг эд хариуцагчаар сар бүр гаргаж холбогдох анхан шатны баримт/ орлого, зарлагын баримт , шаардах хуудас/-ыг хавсаргаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ГАНСҮХ



БЭЛТГЭСЭН: ДӨЛГӨӨНХАЙРХАН-УУЛ

АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Д.ДАШЗЭВЭГ

2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 15-НИЙ ӨДӨР